



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

“Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох
актуарын стандарт үнэлгээ актуарчийн хяналт
шалгалт хийх, тайлан гаргах журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам“-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**АКТУАРЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ ОЛГОХ БОЛОН
АКТУАРЫН СТАНДАРТ ҮНЭЛГЭЭ БОЛОН АКТУАРЧИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ, ТАЙЛАН ГАРГАХ ЖУРАМ**

/Энэ журмын нэрэнд Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос гаргасан заавар журмын хүрээнд мөрдөгдөнө.

Хоёр. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох

2.1. Хороо дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “этгээд” гэх)-д актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгоно:

2.1.1. Эдийн засагч, статистикч, санхүүч, математикч, эконометрикч зэрэг мэргэжлээр их дээд сургуулийн хөтөлбөрийг хангасан;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.1.2. Актуарын чиглэлээр гадаадын болон дотоодын тусгай курст, сургалтад суралцаж төгссөн;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

~~2.1.3. Гадаад улсад актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан;~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор хассан/

~~2.1.4. Энэхүү журмын хавсралтаар батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох сургалтын хөтөлбөр”-ийн эхний 2 үе шатны сургалтын шаардлагыг хангасан. ;~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор хассан/

2.1.5. Олон улсын актуарчдын холбоо болон түүний жинхэнэ гишүүн байгууллагаас зохион байгуулсан магадлалын онол болон санхүүгийн математик сэдвийн хүрээнд шалгалт өгч тэнцсэн;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор нэмсэн/

2.1.6. Олон улсын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдэд энэхүү журмын 2.1.1-2.1.3 дахь шаардлагыг хангасан эсэхээс үл хамааран актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгож болно.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор нэмсэн/

2.2. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохыг хүссэн этгээд Хороонд өргөдлөө энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаж байгааг нотолсон баталгаажуулсан баримтын хамтаар ирүүлнэ.

2.3. Хороо энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан этгээдэд актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах чиглэлээр олгоно:

2.3.1. Урт хугацааны даатгалын;

2.3.2. Ердийн даатгалын.

2.4. Актуарын үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээд зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүр Хороонд төвлөрүүлнэ.

2.5. Актуарчийг энэ журмын 2.3-д заасан чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж, тухайн чиглэлээр мэргэшсэн гэж үзвэл мэргэшсэн актуарчийн эрхийг олгоно.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор нэмсэн/

Гурав. Актуарын үйл ажиллагааны стандарт үнэлгээ

3.1. Актуарч нь үйл ажиллагаандаа актуарын дараах стандарт үнэлгээг хэрэгжүүлнэ:

3.1.1. Даатгалын үнэлгээн дээр үндэслэсэн даатгалын хураамжийн хувь хэмжээг тооцох;

3.1.2. Даатгалын нөөцийн сан, даатгалын компанийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцох;

3.1.3. Тухайн санхүүгийн жилийн эцэст даатгалын гэрээнээс үүссэн үүрэг болон нөхөн төлбөрийг тооцох;

3.1.4. Тухайн санхүүгийн жилд даатгалын сангуудтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт гарсан өөрчлөлт болон холбогдох үзүүлэлтийг үнэлж тооцох;

3.1.5. Даатгагчийн боловсруулсан даатгалын шинэ бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээг тооцох;

3.1.6. Даатгагчийн төлбөрийн чадварын түвшинд үндэслэн санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо судалгаа хийх.

3.1.7. Давхар даатгалын хуваарилалт, эрсдэлийн тооцоо, хөрөнгийн хүрэлцээг үнэлэх;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор нэмсэн/

3.1.8. Хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, үнэлэлт өгөх;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор нэмсэн/

3.1.9. Ашгийн зохистой хуваарилалтын дүгнэлт гаргах.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор нэмсэн/

Дөрөв. Актуарын хяналт шалгалт хийх, тайлан гаргах

4.1. Даатгалын компани энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасан актуарын үйл ажиллагааны үнэлгээ, хяналт шалгалтыг жил бүр хийлгүүлнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.2. Актуарч нь энэхүү журмын хавсралтаар батлагдсан “Актуарын тайлангийн стандарт”-д заасны дагуу актуарын хяналт шалгалтын тайланг бэлтгэнэ;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.3. Актуарч нь шалгалтын тайлан, тухайн компанийн талаарх актуарын дүгнэлтийг шалгалт хийж дууссанаас хойш 30 хоногийн дотор даатгагч болон Хороонд хүргүүлнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.4. Хороо тухайн компанийн актуарын шалгалтын тайланг хүлээн авч, шаардлагатай тохиолдолд тухайн актуарчийн хийсэн дүгнэлтийн талаар тодруулга тайлбар авч болно.

Тав. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1. Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

5.1.1. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хуурамч баримт бичиг бүрдүүлэх замаар авсан болох нь тогтоогдсон;

5.1.2. Актуарч дүгнэлтээ даатгагчийн ашиг сонирхолд нийцүүлэн гаргасан болох нь тогтоогдсон;

5.1.3. Хорооны улсын байцаагч актуарын үйл ажиллагаагаа хангалтгүй биелүүлж байна гэж үзэж удаа дараа алдаагаа засахыг шаардсан;

5.1.4. Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төвлөрүүлээгүй.

5.2. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

5.2.1. Хорооноос тогтоосон 6 сар хүртэл хугацаагаар;

5.2.2. Хорооноос өгсөн хугацаатай үүрэг даалгавар, албан шаардлагыг биелүүлэх хүртэл.

5.3. Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

5.3.1. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд хүсэлтээ гаргасан;

5.3.2. Актуарчийн үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлж, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, багц дүрмийг ноцтой зөрчсөн;

5.3.3. Түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан албан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлээгүй.

5.4. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгавар, албан шаардлагыг биелүүлж ажилласан гэж үзсэн тохиолдолд Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээж болно.

Зургаа. Хүлээлгэх хариуцлага

6.1. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

”Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох
 актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн
 хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам“-ын хавсралт
*/Энэхүү хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны
 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 335 дугаар
 тогтоолоор өөрчилсөн/*

АКТУАРЫН ТАЙЛАНГИЙН СТАНДАРТ

1. Актуарч даатгагчийн актуарын тайланг бэлдэхдээ энэхүү стандартын дагуу боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.
2. Актуарын тайлан нь дараах аг

Үе шат	Сургалтын сэдэв	Сургалтын шаардлага	
1. Ерөнхий мэдлэг олгох	Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт орсон хичээл:	Нийт 60 кредит цагаас дээш	
	1.1. Математик		
	1.1.1. Математик анализ (дээд тоо)		
	1.1.2. Алгебр, дифференциал тэгшитгэл		
	1.1.3. Үйлдлийн ба системийн шинжилгээ		20
	1.1.4. Математик тооцооллын аргачлал		
	1.1.5. Санхүүгийн математик		
	1.1.6. Эконометрикс		
	1.2. Магадлалын онол, статистик загварчлал		
	1.2.1. Магадлалын онол		
	1.2.2. Статистикийн онол		20
	1.2.3. Эдийн засгийн загварчлал		
	1.2.4. Математик (статистик) загварчлал		
	1.2.5. Бизнесийн статистик		
	1.3. Эдийн засаг, санхүү		
	1.3.1. Эдийн засгийн онол		
	1.3.2. Мөнгө, санхүүгийн онол		15
1.3.3. Даатгал			
1.3.4. Эдийн засгийн менежмент			
1.3.5. Санхүүгийн удирдлага			
1.3.6. Санхүүгийн хөрөнгө оруулалт			
1.4. Санхүүгийн тайлагнал			
1.4.1. Нягтлан бодох бүртгэл	10		
1.4.2. Зардлын бүртгэл			
1.4.3. Санхүүгийн бүртгэл			
1.4.4. Санхүүгийн тайлангийн аудит			
2. Тусгай сургалтад хамрагдах	Актуарын болон даатгалын чиглэлээр тусгай курс, сургалтын хөтөлбөрт орсон хичээл:	Нийт 40 цагаас дээш	
	2.1. Даатгалын актуарын тооцоолол		20
	2.2. Даатгалын эрсдэлийн удирдлага		15
	2.3. Ердийн даатгалын менежмент		10
	2.4. Урт хугацааны даатгалын менежмент		10

3. Мэргэшиж дадлагажих	3.1. Нарийн мэргэшүүлж, актуарчийн дадлага олгох хугацаа 3.2. Актуарчийн мэргэшил дээшлүүлэх чиглэлээр тусгай курс, сургалтанд орсон хичээл: 3.2.1. Ердийн даатгалын актуарын сургалт 3.2.2. Урт хугацааны даатгалын актуарын сургалт	5 жилээс дээш 2 жилд 1 удаа 20 цагаас дээш 20 20
------------------------	--	--